

МОНГОЛ УЛСАД ОРЧИН ЦАГИЙН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАГДСАН НЬ

Т.ЕТЕКБАЙ

Товч утга: 1911 онд тусгаар тогтносон Монгол улсад хэвлэлийн үйлдвэр хэрхэн байгуулагдсан түүхийг, 1912 онд байгуулагдсан Орос-Монголын хэвлэлийн хороо, 1912 оны сүүлчээр Гадаад яамны дэргэд байгуулагдсан Монгол хэвлэлийн хороо, 1916 онд байгуулагдсан Шанзавын яамны хэвлэлийн үйлдвэр хэмээх анхны гурван хэвлэлийн үйлдвэр байгуулагдсан нөхцөл шалтгаан, үйл явцыг архивийн баримт, дээрх хэвлэлийн газартай холбогдох хүмүүсийн дурсамж болон өмнөх судалгаанд тулгуурлан тоймлон гаргав.

Түлхүүр үг: Орос-Монголын хэвлэлийн хороо, Монгол хэвлэлийн хороо, Орос хэвлэлийн хороо.

1. “Орос-Монголын хэвлэлийн хороо” байгуулагдсан нь

XX зууны эхээр, ялангуяа Богд хаант Монгол Улс байгуулагдмагц төр засгаас явуулах бодлого, шийдвэрийг сурталчлах, чухал хэрэгцээтэй хууль шастир болон шинэ тутам байгуулагдсан сургуулийн сурах бичиг, албаны шугмаар мөрдөх журам дүрэм зэргийг нэн даруй хэвлэн гаргахын тулд хэвлэлийн орчин цагийн шинэ бааз суурь шаардлагатай болов. Гар ажиллагаатай, үр бүтээл багатай өмнөх үеийн модон барын хэвлэлийн аргаас хорголжин үсгийн бар ашиглан хэвлэх техникжсэн аргад шилжих явдал тун амаргүй хэрэг байсан хэдий ч, хэвлэлийн шинэ арга өөрийнхөө давуу талаараа Монгол Улсын соёлын хөгжилд асар их өгөөж авчрах нь тодорхой байсан юм. Өрнөдийн орнуудад олон жил хэрэглэж, үр дүнгээ нэгэнт өгсөн хэвлэлийн техникжсэн аргыг Монгол оронд нэвтрүүлэх нь тусгаар тогтнолоо бататган бэхжүүлэх, нийгмийн оюун санааг нэн даруй өөрчлөн шинэ зорилт руу хөтлөн залахад чиглэгдсэн түүхэн үйл явдал мөн байлаа. Монгол Улсад техникийн тусламжаар гүйцэтгэдэг орчин цагийн хэвлэх үйлдвэр байгуулах шаардлага нэгэнт бий болсныг Монголын засаг ноёд төдийгүй, Монголд ажиллаж байсан Орос Улсын үйлдвэрийн эзэд, худалдаачид мөн анзаарчээ. Нийслэл Хүрээнд хэвлэлийн үйлдвэр нээж ажиллуулж ном, сонин, сэтгүүл зэрэг нэн хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж багагүй ашиг олж болохыг тэд урьдчилж тооцоолж байсан нь илт байна.

Тэр үед нийслэл Хүрээнд ажиллаж байсан Оросын худалдаачин Ф.Москвитин улсаас дэмжүүлэх замаар хэвлэх үйлдвэр ажиллуулах бодолтой байгаагаа Санкт-Петербургт байсан Сангийн яамны түшмэл В.Котвичид 1912 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр бичсэн захидалдаа илэрхийлж байжээ. Тэрээр,

“Хэсэг нөхөдийн хамт би хэвлэлийн хороо байгуулж буй бөгөөд монгол үсгийн тэмдэгтийг санамсаргүй Эрхүүгээс олж авлаа. Одоо эхлээд хэвлэлийн хорооны зардлаар монгол хэдэн сонин үнэгүй гаргая. Дараа нь консулын газраар дамжуулан, хэрэв энд Коростовец ирэх бол, түүгээр туслуулан сонинд улсаас тэтгэлэг гаргаж өгөхийг санал болгох бодолтой байна. Таныхаар, жилд хэдэн мянган тэтгэлэг авах боломж гарах бол оо, аль эсвэл тийм боломж гарахгүй болов уу”¹

гэж бичиж байсан бол, түүний саналыг дэмжиж Хүрээн дэх Оросын ерөнхий консул В.Люба 1912 оны 9 дүгээр сарын 12-нд Оросын Гадаад хэргийн яаманд хандан айлтгал өргөж хэвлэх үйлдвэр байгуулж, сонин хэвлэх мөнгө хөрөнгө тэрээр Яамнаас хүссэн байна².

Монгол дахь Орос Улсын Бүрэн эрхт төлөөлөгч И.Я.Коростовец Монголыг Оросын талд татах олон арга сүвэгчилж ирсний дотор сонин хэвлэж тараах замаар монголчуудыг сэнхэрүүлж, ойртуулах бодолтой байсан юм. Оросын Бүрэн эрхт төлөөлөгч И.Я.Коростовец нийслэл Хүрээнд хүрэлцэн ирэнгүүтээ Москвитинтэй уулзаж, монгол хэл дээр сонин гаргах асуудлаар санал солилцжээ. Я.Коростовец түүнийг хамтран ажиллаж хэвлэх машин олж авахад туслахыг хүсэхэд Ф.Москвитин “Орос сонин гаргана гэж авчирсан хэвлэх машинуудаас олж авах нь зөв”³ гэж тэрээр зөвлөсөн байна.

Ф.Москвитины хэсэг нөхөдгэдэг нь Нийслэл Хүрээндэх Оросын консулын ажилтан Иванов, цэргийн офицер Малиновский нар байжээ. И.Коростовец Эрхүүгээс захиалж авчруулсан хэвлэх машинуудыг монголчуудад их бууны анги салбар зохион байгуулж өгч байсан, сургагч офицер Малиновскийгээс олжээ. Тэр тухай,

“Тэрээр орос сонин гаргах бодолтой явдаг ч мөнгө хөрөнгө нь хүрэлцэхгүй учир бүтээгүй явсан юмсанж. Хэвлэх машин болон үсгүүдийг худалдаж авсан, монгол сонин гаргах хүсэл төрлөө. Зардал гарах учраас энэ санааг минь Петербург дэмжихгүй нь илэрхий болохоор эрсдэлийг нь өөрөө хүлээн, бие дааж шийдвэрлэх болов”⁴

гэж Коростовец бичиж байв.

Ийнхүү Оросын худалдаачны Ф.Москвитиний 1912 оны 9-р сард В.Котвичидилгээсэн захидалдаа хэвлэлийн хороо байгуулж байгаа мэтээр бичсэн боловч, үнэн хэрэг дээр энэ хэвлэлийн хороог түүнтэй хамтрагч Монгол дахь Оросын цэргийн офицер Малиновский байгуулжээ. Энэ хэвлэх үйлдвэр нь 1912

¹ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг, УБ, 1972, 251.

² Коростовец И.Я. Монголд өнгөрүүлсэн есөн сар, УБ, 2010, 279.

³ Мөн дээрх 130.

⁴ Мөн дээрх 150.

оны 10 дугаар сарын 21-нд гарын үсэг зурсан Орос-Монголын найрамдлын гэрээ бичгийн дагуу Орос Улсын харъяат иргэдэд давуу эрх олгохоор тогтоосон жагсаалтын нэгдүгээр зүйлд,

“Их Орос Улсын харъяат хүн нар Монгол Улсын харъяат олон газар суух явах ба элдэв зүйлийн худалдаа нэвтрүүлэх, эд боловсруулах ба бусад аж үйлдвэр хийх ... эрхийг хуучин ёсоор хэрэглэнэ”⁵

гэсэн заалтын дагуубайгуулагдсан гэж үзвэл зохино. Учир нь уг хэвлэх үйлдвэрийн нээлтийн ёслол гэрээ батлагдсаны дараа ердөө 20 хүрэхгүй хоногийн дотор болсон бөгөөд тэнд үг хэлсэн хүмүүс тун итгэлтэй байсан ажээ.

Энэ талаар И.Я.Коростовец 1912 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн тэмдэглэлдээ,

“Монгол улсын их бууны анхны ангийн үзлэгийн дараа Малиновский биднийг өөрийнхөө байгуулсан орос-монгол хэвлэх үйлдвэрийн нээлтэд урилаа. Хэвлэх машиныг бидний дэргэд шууд залган ажиллуулав. Хэвлэх үйлдвэр алгын чинээ хоёр жижигхэн өрөөтэй, нэгэнд нь Троицкосавскаас ирсэн орос дарга нь суух болжээ. Оригилуун дарс ууж, таатай үг хэлцгээлээ. Үнэндээ бол энэ хэвлэх үйлдвэр минийх бөгөөд Петербурт захиалсан монгол үсэг ирмэгц монгол сонин хэвлэх ажилд ашиглах юм. ... Монгол сонин хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжинд зориулж Малиновскийд 1000 рубль би өглөө”⁶

гэжээ. Дээр дурдсанчлан, энэхүү хэвлэх үйлдвэрийг Я.Коростовец өөрийн мэдэлд авахаар шийдвэрлэж, албнаасаа мөнгө гаргаж хэвлэлийн тоног төхөөрөмжийг 1912 оны нэгдүгээр сарын 4-нд худалдан авсан ажээ. Энэ тухай тэмдэглэлдээ,

“Иванов, Малиновский нараас би 3500 рублиэр хэвлэх үйлдвэр худалдан авч Консулын газрын мэдэлд шилжүүллээ. Хэвлэх үйлдвэрт миний авч үлдсэн 2 орос ажилчин үсэг өрөгч, механикчаар ажиллах болно”⁷

гэжээ. Ийнхүү тэрээр хэвлэх үйлдвэрийн үнэ хэмээн нийт 4500 рубль өгсөн байна. Консулын мэдэлд шилжсэн энэ хэвлэх үйлдвэрт ажиллахаар үлдсэн эдгээр орос хүмүүс нь хэвлэлийн механикч бөгөөд үсэг өрөгч байсан М.И.Кучеренко, коммунист үзэлтэй В.Я.Кондаков нар байжээ.

И.Я.Коростовец хэвлэх үйлдвэрт зориулж Монголын талаас байр гаргаж өгөхийг хүссэн ажээ. Тэр тухай,

⁵ Магсаржав Н. *Монгол Улсын шинэ түүх*, УБ, 2010, 62-63.

⁶ Коростовец И.Я. *Монголд өнгөрүүлсэн есөн сар*, УБ, 2010, 170-171, 178.

⁷ Мөн дээрх, 245.

“Монгол сонин гаргах хэвлэх үйлдвэрт зориулсан байр монголчууд надад гаргаж өглөө. Өмнө нь хятадууд ашиглаж байсан хоёр давхар модон байшин⁸ ажээ. Сайн хэрэг, ингэхгүй бол шинээр байшин барих ажил гарах байлаа”⁹

гэж Коростовец баярласан сэтгэгдлээ бичжээ. Монголын талаас хэвлэх үйлдвэрт зориулж байр гаргаж өгсөн нь энэ үйлдвэр монголчуудын эрх ашгийн төлөө ажиллаж, хэвлэлийн хэрэгцээтэй зүйл хэвлэх болсонтой холбоотой байсан юм.

1913 оны 5 дугаар сард И.Я.Коростовец эх орондоо буцах болж түүний халааг авахаар Миллер гэдэг хүн иржээ. Я.Коростовец явахынхаа өмнө,

“Коковцовын¹⁰ надад гаргаж өгсөн 100 мянган рублиэс үлдсэн 7 мянга гаруй рублийг би Миллерт өглөө. Тэрээр миний байгуулсан хэвлэх үйлдвэр болон сонинд уг мөнгийг зарцуулахаа амлалаа”¹¹

гэжээ. Энэ нь Коростовецийн хөөцөлдөж хэвлүүлж байсан “Шинэ толь хэмээх бичиг” сонингоо үргэлжлүүлэн хэвлүүлэх болон хэвлэх үйлдвэрийн урсгал зардлыг хаахад зарцуулахыг хэлж буй хэрэг юм.

Монголын түүхэнд “Орос-Монгол хэвлэлийн хороо” хэмээн нэрлэгдсэн хэвлэлийн энэ үйлдвэр нь Консулын сууринд байрлаж байсан талаар 1920 онд М.Торновский,

“Хүрээнээс Наймаачин явах зам руу явсан замын дагуу нэг километр орчим үргэлжилсэн ганц том гудамж болон эгнэжээ. Энд европчууд байрласан аж. Хоёр давхар байшинтай Оросын Ерөнхий консулын газар, Өргөөгийн хамгийн том барилга болох Монголор, Консулын үнэн алдартны сүм, хэвлэх үйлдвэр, шуудан, орос офицеруудын байр, монгол орчуулагчдын сургууль, маш олон модон болон чулуун байшин, жижиг жижиг орос байшингууд зэрэг. Орчин суугчид гэвэл 250 орос хүн, Хүрээнд арай ойрхон, Сэлбэ голын гарамны дэргэд 100 хүрэхгүй үгүйтэй монгол амьдарна”¹²

хэмээн бичсэн буй.

Орос, Монгол аль алины үсгийн санг хэрэглэн ажиллаж болох техник, төхөөрөмж бүхий хэвлэлийн энэ үйлдвэр Оросын төмөр замыг бараадан Харбин хотод ажиллаж байсан үйлдвэрээс улбаатай бөгөөд дарга Эповыгаас эхлэн ажилчид

⁸ Монголорын захирал Гротын бариулсан байшин.

⁹ Коростовец И.Я. *Монголд өнгөрүүлсэн есөн сар*, УБ, 2010, 290.

¹⁰ Оросын сангийн сайд.

¹¹ Коростовец И.Я. *Монголд өнгөрүүлсэн есөн сар*, УБ, 2010, 390.

¹² Торновский М.Г. События В Монголии в 1920-1921 годах. Военно-исторический очерк, Воспоминания, Легандарный барон: Неизвестные страницы гражданской войны, Составитель и редактор С.Л.Кузьмин. Москва, 2004, 179.

нь хүртэл Харбинаас шилжин ирэгсэд байв¹³. Түүнээс гадна хэвлэлийн зарим машиныг бусад хотоос оруулж ирсэн, тухайлбал Оросын хөрөнгөтнүүд 1912 онд Дээд Үүд хотоос хэвлэлийн машин авч жижиг оврын хэвлэх үйлдвэрийг Нийслэл хүрээнд нээн ажиллуулсан билээ¹⁴. Өөрөөр хэлбэл, энэ үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, үсэг хэрэгслийг Эрхүү, Дээд Үүд, Харбин хотуудаас авчиржээ. Чухам ийм бэлэн суурь бүхий энэ хэвлэх үйлдвэрийг нийслэл Хүрээнд шилжүүлэн ажиллуулахад Оросын цэргийн техник хэрэглийн хамторуулж ирсэн учраас техник төхөөрөмж, материал хэрэгсэл, ажиллах хүчний хувьд бэрхшээл төдий л гараагүй бололтой. Харин худалдаачин Ф.Москвитины Эрхүүгээс олж авчирсан болон Харбинд хэрэглэж байсан монгол үсгийн тэмдэгт нь хуучирч муудсан учир шинэ үсгийн тэмдэгтийг Петербургээс захиалж авах шаардлага гарчээ. Үсэг хуучирч муу байснаас тэнд хэвлэгдсэн “Шинэ толь” сонин анхны дугаарын хэвлэлт тааруу болсон талаар И.Я.Коростовец дурдсан байдаг.

Монгол Улсын хувьд тэр үед ном хэвлэлийн хэрэгцээ шаардлага их байсан боловч орчин цагийн хэвлэх үйлдвэр ажиллуулахаар бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчин байсангүй. Тийм учраас хэвлэх үйлдвэр байгуулах аливаа санал санаачлагыг Монголын засгийн газраас дэмжих нь зүй ёсны байжээ. Иймд цэргийн офицер Малиновский хувийн хэвлэх үйлдвэр байгуулахад Монголын засгийн газрын зүгээс саад учруулаагүйгээр барахгүй дэмжиж байсан нь илт ажээ. Малиновскийн байгуулсан хэвлэлийн хороо нь Монгол улсын эрх ашгийн төлөө ажиллах болсон учир уг хэвлэлийн газрыг Орос-Монгол үсгийн хэвлэлийн хороо, монголчууд “Шинэ толь”-ийн хороо ч гэж нэрлэж монгол, орос ажилчид ажиллаж, Монгол Улсын засгийн газрын Оросын бүрэн эрхт элчин төлөөлөгчтэй хийсэн хэлцлийн дагуу хэвлүүлэхээр шийдвэрлэсэн анхны монгол хэвлэл “Шинэ толь хэмээх сонин бичиг” сэтгүүл, түүний дараагийн анхдугаар сонин бичиг “Нийслэл Хүрээний сонин”, мөн төрөл бүрийн ном товхимол мөн тэнд хэвлүүлж байсан юм.

Оросын эрдэмтэн И.М.Майский “1913-1918 онд Монголд Хятад, Оросын дунджаар арваад ажилчинтай, 700 орчим жижиг үйлдвэрийн газар ажиллаж байлаа”¹⁵ гэж тэмдэглэсэн байдаг. Тэдний нэг нь Оросын худалдаачдын байгуулсан нийслэл Хүрээнд үйл ажиллагаа явуулдаг “Орос-Монгол хэвлэлийн хороо” буюу Консулын хэвлэл байсан ажээ.

2. Монгол хэвлэлийн хороо байгуулагдсан нь

Ийнхүү тусгаар тогтносон Монгол улсын нийслэл Хүрээ хотноо байгуулагдсан орчин цагийн анхны хэвлэлийн үйлдвэр “Орос, Монгол үсгийн хэвлэлийн хороо”-нд сургуулийн сурах бичиг, нийтэд зориулсан ном хэвлэлийг

¹³ Зууны босгыг барласан түүх, УБ, 2012, 6.

¹⁴ Урангуа Ж. Монголын тусгаар тогтнолд хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс, УБ, 2010, 70.

¹⁵ Майский И.М. Монголия накануне революции, Москва, 1960, 191.

хэвлүүлэх нь нээлттэй байсан хэдий ч, тусгаар тогтносон Монгол Улсын хувьд хэвлэлийн бүх зүйлээ Орос худалдаачны хэвлэлийн хороонд хэвлүүлэх нь зохимжгүй байсан төдийгүй, гадаад дотоод улс төрийн бодлоготой холбоотой зарим хэвлэмэл баримт бичгээ нууцлах, гаргасан бодлого шийдвэрээ гадны ямар нэгэн нөлөөгүйгээр олон түмэнд шууд таниулахын тулд өөрийн гэсэн хэвлэх үйлдвэр байгуулах явдал чухал байлаа. Хэвлэх үйлдвэр байгуулж тэнд ажиллуулах мэргэжил эзэмшүүлэхээр “1912 онд алтан шүдэт Намсрай, хялааз Намсрай гэдэг хүмүүсийг Харбин хотын “Юан Био-тан” гэдэг гудамжны хэвлэлийн газарт явуулж, мэргэжилтэй ажилчныг бэлтгэжээ”¹⁶. Ийнхүү хэвлэлд ажиллах хүнээ урьдчилан бэлтгэж авсан Гадаад Явдлын яам Монголын өөрийн хэвлэх үйлдвэр байгуулах санаачилга гаргасан ажээ.

Чухамхүү тусгаар тогтносон улсын засгийн үйл хэргийн төлөө ажиллуулахаар тэр үед Монгол Улсад сууриа тавьсан орчин цагийн хоёр дахь хэвлэх үйлдвэр нь Гадаад явдлын яамны дэргэд байгуулагдсан хэвлэлийн газар буюу Монгол хэвлэлийн хороо байсан юм. Монгол улсад анхны хэвлэлийн үйлдвэрийн суурийг хэрхэн тавьсан талаарх баримт бичиг Үндэсний Төв Архивт хадгалагдан үлдсэн байна. Тухайлбал, Монгол улс 1912 онд Орос улсын нийслэл Петербург хотоос шинэ янзын хэвлэлийн машин, үсгийн хэв худалдан авах тухай бусад яамдад хандан Гадаад яамнаас Олноогийн 2 дугаар (1912) оны 10 дугаар сарын 18-нд үйлдсэн баримт бичигт,

“Сонсвоос Орос улсад төмөр хэвээр сийлсэн монгол дан үсгийн хэв ба дармал дарах эргүүлэг үнэ асар ихгүй, хэрэглэхэд маш түргэн тустай хэмээх учир хүнээр захиалан асуусанд монгол дан үсгийн төмөр хэв 5 пүү болбоос хэрэглэж хүрэлцэнэ. Үнэ нь цөлхөөв цаас 2 хуудас, бас дармал дарах эргүүлэг нэг бүрийн үнэ цөлхөөв цаас нэг мянган хуудас, эдгээрийг Орос улсын нийслэлээс Хиагтад түргэн ирүүлэх хөлсөнд цөлхөөв цаас хоёр зуун хуудсыг хэрэглэнэ. ... Үүний тулд 5 яамнаас яаравчлан зөвлөхөөр явуулав. Хариуг хуудсаар ирүүлнэ үү.”¹⁷

гэжээ. Хэвлэх машин худалдан авах тухайд,

“Гадаад яамнаас Бүгд Ерөнхийлөн захирах, Дотоод, Цэргийн, Шүүх яамнаа хуудсаар илгээх учир, Орос улсаас монгол дан үсгийн төмөр хэв ба дармал дарах эргүүлэг нэг бүрийн үнэ хөлсийг Сангийн яамнаас тавин олгож, худалдан авч авчруулах, аливаа дармал дарж хэрэглэх зүйлд үргэлжид түргэн тус болгож болох эсэхийг хуудсаар зөвлөхөөр явуулсанд, Дотоод яамнаас энэ нь хялбараар олдох их л хэрэг байх мэт. Харин хэмжээ маягийг энд хэрэглэж болохоор захивал сайн бол уу. Энэ удаа

¹⁶ Содномдаржаа Т. *Монгол ард улсын ном хэвлэлийн хураангуй түүх*, УБ, 1965, 11.

¹⁷ МУУТА, А-6, Д-31, ХН-100.

түвд үсэг захихыг азнавал ямар хэмээн цохсон ба Цэргийн, Сангийн яам цөм Дотоод яамны цохсон зүйтэй, Шүүх яам ийнхүү хэвийн үсэг авах нь зүйтэй. Бүгд Ерөнхийлөн Захирах яамнаас энэ удаа түвдийн хэв хэрэглэх зүйл бага тул түүнийг зогсоож, монгол үсгийн хэвийг даруй зохих газар захиалгаар явуулж ирүүлэх нь маш эрхэм, хурдханаар завдаж ирүүлэлтэй.”¹⁸

хэмээх хүсэлт гарган тус тус цохож ирүүлжээ. Ингээд Гадаад яам дээрх таван яаманд дараах мэтүүрэг болгов.

“...Энэ зүйлийн хэв ба эргүүлгийг зүй нь манай яамны тэргүүн сайд орос улсад одох ялдамд хэмжээ маягийг үзэж аваад хурдханаар нааш түргэлүүлбэл болох тул үүнийг Сангийн яамнаа явуулаадолдвоос хэрэглэх үнэ хөлсөнд элбэг хүрэлцэхийг бодож цөлхөөв цаас нэгэн мянган таван зуун хуудсыг гаргаж манай яамнаа түргэн ирүүлэх ажаамуу. Олноогийн хоёрдугаар он, арван сарын хорин”¹⁹

Тийнхүү 1912 онд Богд хаант улсын Гадаад яам, Орос улсаас монгол дан үсгийн төмөр хэв дармал дарах эргүүлэг худалдан авах санаачилга гаргаж бусад таван яам хамтран хэлэлцэж санал нийлжээ.

Түргэн ажиллагаатай орчин цагийн хэвлэх үйлдвэртэй болохын тулд төрийн бүх яамд оролцон саналаа нэгтгэн үнийг нь гаргуулан нэн даруй авахаар шийдвэрлэжээ. Харин Засгийн газрын энэ шийдвэр нь Гадаад явдлын яамны сайд Орос улсад айлчилсан үетэй давхцан биелэлээ олжээ. Гадаад яамны тэргүүн сайд Ханддорж, шүүх яамны дэд сайд Ширнэндамдин, Гадаад яамны түшмэл Б.Цэрэндорж, эх зохиогч түшмэл Бавуудорж нарын бүрэлдэхүүнтэй Богд хаант Монгол Улсын засгийн газрын төлөөлөгчид 1912 оны өвлийн дунд сарын 14-нд нийслэл Хүрээнээс гарч, мөн оны өвлийн сүүл сарын шинийн 4-ний үдэш Оросын нийслэл Петербург хотод хүрэлцэн очоод 1913 оны хаврын дунд сарын 7-ныг хүртэл хоёр сар гаруй байсан ажээ. Үүнийг үндэслэж, зарим судлаач “хэвлэлийн машин үсгийг 1912 онд багтаан авчирч үйлдвэрийг ашиглалтанд оруулсан байх боломжгүй”²⁰ гэж үзсэн бол, зарим хүмүүс энэ үйлдвэр 1911 ондажилаж эхэлсэн гэдэг.

Оросоос авах ачаа бараа бэлэн байсан тул даруй Монголд хүргэхээр шийдвэрлэж,

“(12 дугаар сарын) хорин нэгнээ эх зохиогч түшмэл Бавуудоржийг дагалдах хэдэн хүнтэй ачаа зүйлийг авахуулан нутаг буцаагаад, үлдсэн

¹⁸ МУУТА, А-4, Д-31, ХН-100. Олноогийн хоёрдугаар он, 6-р дэвтэр.

¹⁹ Мөн дээрх.

²⁰ Хавчуур Г. *Монголын хэвлэлийн үйлдвэрлэлийн түүх*, УБ, 2007, 27.

сайдуудтүшмэл хэлмэрч дагалдагсадцөм галтгэргэндсууж хорин хоёрноо
Оросын нийслэлд дахин хүрч мөн сангаас бэлтгэсэн гэрт буув”²¹

гэж тайлагнасан байна. Хэвлэх машин, үсэг Бавуудоржийн авчирсан ачаан дотор байсан гэж үзвэл, хэвлэх үйлдвэр 1912 оны сүүлээр байгуулагдсан байх бүрэн боломжтой юм. М.Хандорж тэргүүтэй төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Цэвээн Жамцарано орчуулагчийн хувиар оролдож, хэвлэх машин авахад чухал үүрэг гүйцэтгэжээ. Энэ талаар Монголд удаа дараа ирж байсан В.Котвич 1923 онд,

“Ц.Жамцараногийн санаачилгаар Оросын шинжлэх ухааны академийн хэвлэх үйлдвэрийн тусламжтайгаар Өргөөнд монгол үсгээр өрж хэвлэдэг Европ маягийн хоёр жижиг хэвлэх үйлдвэр байгуулав. Үүний нэгийг нь монголын засгийн газрын хэрэгцээний ном, бичиг хэвлэхэд, нөгөөгийг нь Оросын консулын харьяанд байгуулав”²²

гэж бичжээ. Үүнээс үзвэл, Ж.Цэвээн Монгол Улсад байгуулагдсан “Монгол хэвлэлийн хороо”, “Орос хэвлэлийн хороо” хоёр хэвлэх үйлдвэрт Петербургээс хэвлэх машин, үсэг материал олж авахад өмнө нь хэвлэлтэй холбоотой байгууллагад ажиллаж байсан болон орос хэл сайн мэддэг хүний хувьд ихээхэн тус хүргэжээ.

Монгол Улсын Гадаад яамны дэргэд 1912 онд хэвлэх үйлдвэр нээж ажиллуулсныг баталж манай эрдэмтэн мэргэд бүтээл туурвилдаа олонтоо тэмдэглэсэн байна. Тухайлбал, эрдэмтэн Я.Цэвэл, “1911 онд манай монголчууд Манж чин улсын эрхшээлээс ангижран салж, Богдхаант монгол улсыг байгуулсны дараа 1912 оны эхээр хаант Орос Улсаас хэвлэлийн машин хэрэгсэл захиалан авч тэр үеийн Гадаад явдлын яамны мэдэлд монгол хэвлэлийн хороо гэдэг жижиг хэвлэлийн газрыг байгуулсан байна”²³ гэсэн бол, түүхч Ж.Болдбаатар энэ үйл явдлын тухай, “1912 онд М.Ханддоржийн санаачлагаар Орос улсаас хэвлэлийн машин, үсгийн хэв захиалан авчирч, Гадаад яамны дэргэд хорголжин барын жижиг хэвлэх үйлдвэр байгуулан, тогтмол сонин, сэтгүүл, ном дэвтэр хэвлэдэг болжээ. Мөн өөрийнхөө хошуу Вангийн хүрээнд төвд ном голдуу, монгол ном бага шиг барладаг хэвлэлийн жижиг газар байгуулан ажиллуулж байв”²⁴ гэжээ. Энд анхаарал татах нэг асуудал бол Ханддорж дайчин вангийн хүрээний барханд, өөртөө засах Монгол Улсын үеэс Орос Улсын Хуандийн шинжлэх ухааны хүрээлэнгийн үсэг цутгах газраас монгол хорголжин үсгийн хамт бага сага төвд хорголжин үсэг захиж ирүүлснээс санаа авч, модоор бас задлан өрөх үсгийн хэв хийж зарим зүйлд хэрэглэж байсан²⁵ нь хэвлэлийн түүхэнд чухал ач холбогдолтой

²¹ Урангуа Ж. *Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс* 1911-1917, УБ, 2010, 160; МУУТА, А-234, Д-1, ХН-63, 151-204.

²² Котвич В. *Среди монгольских племён*, Восток, Кн. 11, Петербург, 1923, 119.

²³ *Номын ууган орд*, УБ, 1972, 47.

²⁴ Болдбаатар Ж. *Эрдэнэ дайчин хошой чин ван Ханддорж*, УБ, 2011, 203.

²⁵ Дашням А. *Монгол оронд хэвлэл үүсч хөгжсөн түүхээс*, УБ, 1962, 10.

зүйл гэж үзүүштэй. Энэ бол яах аргагүй монголчууд ХХ зууны эхэнд монгол үсгийн дагнасан хэвийг өөрснөө бүтээж хэрэглэж байсныг нотлох баримт юм.

Дээр дурдсан Үндсэний архивын түүхэн баримт, Гадаад явдлын сайдын Орос Улсад хийсэн айлчлал, эрдэмтэдийн туурвисан бүтээлийг үндэслэж Гадаад яамны дэргэд байгуулагдсан хэвлэх үйлдвэрийг 1912 оны сүүлчээр ашиглалтанд орсон гэж үзэх нь үндэслэлтэй байна.

1962 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Хэвлэлийн хэрэг эрхлэх хороон дээр Монгол Улсад орчин цагийн хэвлэл хэдийд буй болсныг тогтоох зорилгоор зохион байгуулсан ярилцлага дээр доктор Б.Ринчен,

“Би 1936 онд Улсын хэвлэлийн газрын нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа Улсын хэвлэлийн газрын дарга асан Дамбийнямтай хамт ер нь хэвлэл хэдэн ондаяж байгуулагдсаныг лавлан судалж, улмаар Петербург очиж Монголд хэвлэл байгуулагдсаныг сайн мэдэх орос нэгэн академич, мөн эрдэмтэн Цэвээн нартай уулзаж ярилцваас 1911 оны 12 дугаар сарын 30-нд хэвлэл байгуулагдсан болохыг тодорхойлон ярьж өгсөн бүлгээ. Хэвлэлийн машинуудыг 1911 онд зээлээр авч тавиад, сүүлд өртгийг нь өгсөн гэж Цэвээн гуай ярьж байсан. ...Анх удаа монгол үсгийг Оросын шинжлэх ухааны академиас авч байсан байна. Петербургт болсон энэ ярианд Оросын нэг академич, Ж.Цэвээн, Дамбийням, Б.Ринчен би оролцсон юм. ... 1911 оны 12 дугаар сарын 30-ны өдөр машин нь ажиллаж эхний даралт хуудсаа авсан байна гэдгийг Дамбийням сайн тэмдэглэж аваад ирсэн боловч дараа зүүнийхний хэрэгт холбогдон үрэгдсэн тул уул материал түүнтэй үүрэгдэн алга болсон байна”

гэсэн бол, энэ ярилцлагад оролцсон Шавийн яамны хэвлэлд ажиллаж байсан Гомбодоо,

“Би тэр үед шавийн яамны үүдний бичээч байсан билээ. Хэвлэл 1911 онд байгуулагдсан нь үнэн байх ёстой. 1911 оны 12 дугаар сарын 30-нд Богдыг Монгол Улсын хаанаар залж байхад хэвлэсэн юм өгч байсныг сайн мэднэ. Ер нь Монголын тулгар төрийг байгуулсныг тохиолдуулан анхны булыг эргүүлсэн нь зүй ёсоор тохирч байгаа бөгөөд тэр үедмандлын тасалбар, Богдын мөргөлийн тасалбар бичиг зэргийг хэвлэдэг байсан”²⁶

гэжээ. Мөн доктор Б.Ринчен 1964 онд хэвлүүлсэн “Монгол бичгийн хэлний зүй” гэдэг бүтээлдээ,

“1911 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Гадаад яамнаа анх хэвлэл нээж Богдод мөргөхөд мутрын адис хүртэх хүмүүсийн нэр, өргөсөн мөнгө тодорхойлох зурвас анх хэвлэсэн тухайн бичиг, тэр анх хэвлэсэн зурвасын хамт байсан нэгэн баримт 1936 онд Улсын хэвлэл өргөтгөн

²⁶ Содномдаржаа Т. *Монгол ард улсын ном хэвлэлийн хураангуй түүх*, УБ, 1965, 84-86.

байгуулсан үеэс олж, Хүрээнд анх хэвлэл бий болсон өдөр, сарыг миний бие сонирхон хөөцөлдсөөр олсон юмсан. Харамсах нь, Улсын хэвлэлийн хуучин бичгийн дотор үлдсэн тэр сонин баримт үзэх гэтэл хаа орсон нь мэдэгдэхгүй болчихлоо”²⁷

гэж бичжээ.

Эдгээр хүмүүсийн ярьсан зүйл архивын болон бусад түүхэн баримтаар нотлогдохгүй байна. Гэхдээ энд дурдаж буй хэвлэмэл зурвас гэдэг нь хэвлэлийн техникийн аргаар бус, харин чулуун барын аргаар хэвлэгдсэн болохыг үгүйсгэж болохгүй юм. Яагаад гэвэл, Орос Улсад захиалсан машин нь бага оворын, хялбар ажиллагаатай Тигель загварын нэг л гар эргүүлэг байсан гэж байгаа юм. Гэтэл Гадаад яамны хэвлэлийн машины тухайд, “...энэхүү хэвлэлийн газар гараар хөдөлгөдөг гурван машинтай, долоон ажилчинтай байв”²⁸ хэмээснээс үзэхэд, өмнө нь олж авсан хэвлэлийн чулуун хорын бар, эргүүлэг байсан мэт.

Хэрэв 1911 онд Богд хаанд мөргөхөд чулуун хорын бар байгаад түүгээр хэвлэлийн дардас гарган авч ашигласан байхыг үгүйсгэхгүй ч, ийм байлаа гэхэд үүнийг хэвлэх үйлдвэр байгуулагдаж ашиглалтанд орсон гэж үзэх нь учир дутагдалтай юм.

Петербургээс хэвлэлийн машин авчраад шинэ аргаар ном хэвлэх арга ажиллагаанд хүмүүсийг сургахыг Ж.Цэвээнд даалгаж байсан ажээ. Энэ тухай,

“...Олон яамны туслах бичээч нар, сургуулийн хөвгүүдээс хэдэн хүнийг сонгон гаргаж манай яамны орос сургуулийн орос үсгийн сургагч Жамцараногоор дармал дарах ялгалыг сургаваас, тусыг олох нь магад...”²⁹

гэж буй. Ж.Цэвээн нь хэвлэл, бичиг соёлын өндөр мэдлэгтэй хүний хувьд уг хэвлэх үйлдвэрийг Орос Улсаас оруулж ирэхэд оролцсон төдийгүй, хэвлэлийн машинд ажиллах хүмүүсийг сургахад тодорхой үүрэг гүйцэтгэсэн ажээ. Гадаад яамны хэвлэх үйлдвэрт ажиллаж байсан Хайдав дурсан ярихдаа,

“Гадаад яамны дэргэд байгуулсан хэвлэлд би үсэг өрөгч байсан юм. Тэр хэвлэлийн даамал нь Ма Хурц, багш нь Дугаржав гуай байсан. Зүүн хүрээний Номчийн аймгийн Лувсан³⁰, Батсүх бичээч нар бас л үсэг өрөгч болсон. Дараа нь Дугаржавын оронд Номчийн аймгийн Лувсан гуай хэвлэлийн даамал болсон. ... Гадаад яамны хэвлэл гэдэг бол одоогийн багшийн сургуулийн хашаанд тэр цагийн Гадаад яамны үүдний бяцхан байшинд байсан юм”³¹

²⁷ Ринчен Б. *Монгол бичгийн хэлний зүй*, УБ, 1964, 58.

²⁸ Дашням А. *Монгол оронд хэвлэл үүсч хөгжсөн түүхээс*, УБ, 1962, 14-15.

²⁹ МУУТА, А4, Д-1, ХН-4.

³⁰ Лувсан хурц биш.

³¹ Содномдаржаа Т. *Монгол ард улсын ном хэвлэлийн хураангуй түүх*, УБ, 1965, 87-88.

гэжээ.

Гадаад яамны харъяаны “тэр хэвлэл байгуулагдсан цагаас эхлэн сургуульд үзэх “Үсгийн цагаан толгой”, “Үг зөв бичих үсгийн дүрэм”, “Оюун түлхүүр”, “Цаасан шувуу”, “Сань цэи жин бичиг” зэрэг уран зохиол, “Улаан сувд эрих”, “Усны ба модны шастир” гэх мэт үлгэр сургаал, “Унших дэвтэр”, “Цаг тооны бичиг”, “Монгол, Орос, Хятад гурван улсын гэрээ”, “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” мэтийн ном дэвтэр хэвлэн нийтэлдэг байжээ³².

Монгол Улс хэвлэх үйлдвэрт зориулж 1913, 1914 онуудад Петербургаас хэвлэх машин, хэвлэлийн үсэг материал авч байжээ. Жишээ нь, Орос Улсаас ийнхүү үйлдвэрийн хэвлэх машин, үсгийн хэв худалдан авахад зарцуулсан мөнгөний хэмжээ хэд байсныг тэр үеийн Сангийн яамны тайланд тусган үлдээжээ. Тухайлбал, Орос Улсын нийслэлд Сангийн яамнаас зарцуулж хүлээж авсан эд юмны 1913 оны тайлан тодорхойлох дансанд, “Гадаад яамнаа авсан бичгийн хэрэгсэл, монгол үсгийн хэв, орос-монголын толь, машины зэргийн үнийн 750 цаас, 40 мөнгө” зарцуулсан хэмээн тэмдэглэсэн, мөн “Гадаад яам ба Эрдэнэ Шанзудбагийн яамны захисан түвэд-монгол үсгийн хэв хийлгэхээр орос түшмэл Котвичид захиж өгсөн цаас 300”³³ гэж буй. Үүнээс үзэхэд дэргэдээ хэвлэх үйлдвэртэй Гадаад яам, шинээр хэвлэх үйлдвэр байгуулахаар зэхэж байсан Эрдэнэ Шанзудбагийн яамны нэр хэрэгцээнд зориулж төвд-монгол үсгийг захиалж авахаар Оросын Сангийн яамны түшмэл Котвичид мөнгө үлдээж байжээ.

Хэвлэх үйлдвэрийн үйл ажиллагаа өргөжиж ном хэвлэлийн хэрэгцээ нэмэгдэж байсны илрэл нь Орос Улсын Петербург хотод олон удаа монгол үсэг захиалж авсан явдал мөн билээ. Ерөнхий сайд Намнансүрэн 1913 оны айлчлалын үеэр монгол үсгийн тугалгын хэв захиалан авчээ. Үүнд, хоёр хайрцаг буюу 51/2 пүд³⁴, 440 рублийн үнэтэй уг бичгийн хэвийг “Словолитник О.И. Лемань-акционерное общество” хэмээх газар хийлгэжээ. Үүгээр зарим нэгэн багахан хэмжээний ном, товхимол, сонин хэвлэн гаргаж байжээ³⁵.

Түүнчлэн “1914 оны 2 дугаар сард 11 фунтын үсгийг Гадаад яам, Сангийн яам хоёрын нэр дээр авчирч өгсөн нэгэн орос хүнд хөлс өгч өгсөн баримт”³⁶, мөн оны 6-р сардорос газар үйлдүүлсэн монгол үсгийн тугалган хэв 4 пүү, 24 пунтийн үсэг авч байсан тухай бичгүүд”³⁷ хадгалагдсан байна. Энддурдсан 11 пунтийн үсэг нь энгийн текст өрөхөд зориулагдсан ба харин 24 пунтийн үсэг нь гарчигийн өрөлтөнд зориулсан үсэгнүүд байгаа юм. Эдгээр үсэгнүүд нь ном хэвлэлд зориулсан

³² Дашням А. *Монгол оронд хэвлэл үүсч хөгжсөн түүхээс*, УБ, 1962, 14-15.

³³ МУУТА, А6, Д-1, ХН-79.

³⁴ Пунт.

³⁵ Урангуа Ж. *Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс, 1911-1917 он*, УБ, 2010, 80.

³⁶ МУУТА, А6, Д-31, ХН-102.

³⁷ МУУТА, А6, Д-31, ХН-100.

дармал үсгийн төрөлд хамрагддаг ажээ.

Монгол номыг хэвлэж ирсэн хэвлэлийн үсэг хэлбэр дүрс, нэрийн хувьд хөгжлийг даган өөрчлөгдөж иржээ. Монгол номын үсэг гурван хэлбэртэй, өөрөөр хэлбэл бичмэл номын бичмэл үсэг, модон барын номын дармал үсэг, хорголжин барын номын гүймэг үсэг болно. Үүнээс сүүлчийн хоёр нь номын дармал үсэг билээ³⁸. Ийнхүү монголын хэвлэлийн түүхэнд энэ үеэс *номын дармал үсэг гэдэг шинэ нэр томъёо хэрэглэгдэх болсон байна.*

XX зууны эхэн үед монголчууд анх удаа гараар хөдөлгөдөг хэвлэлийн машинтай болж, эх хэлээрхээ элдэв ном дэвтэр хэвлэх болсон явдал бол олон зуун жилийн турш модон бараар ном судар хэвлэж байсан өмнөх үеэтэй харьцуулахын аргагүй томоохон дэвшил байлаа. Гадаад яамны харьяанд байгуулагдсан энэхүү хорголжин барын жижигхэн хэвлэх үйлдвэр нь монголын орчин цагийн хэвлэх үйлдвэрийн анхны суурь болжээ. Монгол Улсад машин техникийн боловсон хэвлэлтэй болохын эх үүсвэр чухамхүү “Монгол хэвлэлийн хороо” гэдэг жижиг хэвлэлийн газрыг тэр үеийн Гадаад Явдлын Яамны мэдлийн дор анх удаа байгуулснаар эхэлжээ³⁹. Энэ бол Монгол Улсын ном хэвлэлийн хөгжлийн түүхэнд гарсан онцгой нэгэн үйл явдал мөн билээ.

Тусгаар тогтносон Богд хаант Монгол Улс өөрийн гэсэн орчин цагийн хэвлэх үйлдвэр байгуулсан нь монголын ард түмнийг соён гэгээрүүлж, хөгжил дэвшилд хөтлөн залахад асар их ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Тиймээс манай улсад орчин цагийн хэвлэлийн үйлдвэр байгуулагдсан цаг хугацааг 1912 оны эцсээр Богд хаант Монгол улсын Гадаад яамнаас санаачилга гаргаж, хэвлэл байгуулах тухай анх хэлэлцэж бичиг үлдсэн 1912 оны 10 дугаар сарын 18-ны өдрийг МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1967 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 157 дугаар тогтоолоор хэвлэх үйлдвэр үүссэн өдөр хэмээн тогтоожээ. Энэхүү тогтоолын заалтаар 1967 оноос хойш Монгол Улсад хэвлэх үйлдвэр байгуулагдсаны ойг тэмдэглэх болсон байна.

3. Их шавийн хэвлэлийн газар

1914 онд Богд хааны дэргэдэх Эрдэнэ Шанзудбагийн газар шашин төрд туслах сайдын яам байгуулж, энэ зуны дунд (долдугаар) сарын 18-ны өдөр ёсолж мялаахад олон яамнаас тухайлан хадаг бэлэг хүргүүлснээс гадна олон сайд цуглаж баяр хуримыг ихэд үйлдэж үлэмж хөлтэй сүртэй юм болсон тухай “Шинэ толь” сонины 1914 оны 16 дугаарт мэдээлсэн байдаг. Тэр үед Богд Гэгээний мэдлийн Шанзавын яам Гадаад яамнаас нэг машиныг нь өөртөө шилжүүлэн, мөн Оросын консулын газраас машин авч 1916 оноос Монгол Улсад гурав дахь хэвлэх үйлдвэр

³⁸ Шүгэр.Ц. *Монгол модон барын ном*. УБ, 1991, 12.

³⁹ Дашням А. *Монгол оронд хэвлэл үүсч хөгжсөн түүхээс*, УБ, 1962, 16.

ажиллаж эхэлжээ. “Тэр гар өрлөгийн хорголжин үсэгтэй хэвлэл Гадаад яаманд анх бий болоод, хэвлэх ном зохиол бүрдээгүй учир олон хувь бичиж явуулах улаан шугамт албан бичгийг үг үсгийг өрж хэвлэн тархааж байсанд Шавь яам түүнийг сонирхон, Гадаад яамнаас нэг суурь хэвлэх машин, нэг хэсэг үсгийн хамт салган авч, шавийн хэвлэл салбарлан байгуулсан байжээ. Шавийн хэвлэл гол төлөв албан бичиг, зарлал эрхлэн, цаг тооны бичиг гэдэг хуанлийн төдийхнийг хэвлэж байсан”⁴⁰ гэж академич Б.Ринчен бичжээ. Өөрөөр хэлбэл, Гадаад яамны хэвлэх үйлдвэрийг ажлаар бүрэн хангаж чадаагүйгээс илүүдэл машин гарч, түүнийг үсгийг нь хамт Шавь яаманд шилжүүлсэн байгаа юм.

Харин Шанзавын яамны хэвлэл анх байгуулагдсан тухай тодорхой мэдэх, тэр үед ажиллаж байсан Эндэн, Гомбожав, Гомбодоо, Гарамсоном, Чойдоо нар,

“Олноо өргөгдсөний 6 (1916) дугаар оны эхээр Шанзавын яамны хашаанд орос маягийн багавтар дүнзэн байшин барьж, хэвлэлийн газар байгуулсан. Тэр хэвлэлд монгол, төвд хоёр төрлийн үсэг, ном хэвлэх, цаас зүсэх гар ажиллагаатай жижигхэн машин тус бүр нэжээд ном өрөх, хэвлэх ажилд хэрэглэх багаж хэрэгсэл нилээд байсан. Шанзавын яамнаас олон отогтоо зарлан тушаах албан хэрэг зэрэг зүйл хэвлэж байхаар энэ хэвлэлийг байгуулсан юм. Тиймэрхүү зүйл гол болгож талиан, муубин, муутуу цаасан дээр 200-2000 орчим хувь хэвлэдэг байв. Энд Эндэн, Чойдоо, Дэндэв, Намсрай нарын 4-5 хүн ажиллаж өрөх, хэвлэх, дэвтэрлэх ажлыг хэн ч ялгалгүй хийдэг байж. Уг нь Их Хүрээний Сэцэн тойны аймгийн лам, хожим Консулын орос хэвлэлд ажил хийж байсан Дамдинжав гэгч тэрхүү хэвлэлийн машиныг анх тавьж өгөөд, тэндээ тавин лангийн цалин авч, уул хэвлэлийг удирдан ажиллуулж байлаа”⁴¹

хэмээн 1960 онд А.Дашнямд ярьсан байдаг.

Шанзавын яамны дэргэдэх хэвлэлд хэвлэгчийн ажил хийж байсан өвгөн Дэндэвийн дурдатгалд,

“Би бичээчийн ажлыг Манж, Автономитын үед даруй 16 жил хийсэн юм. Бичээчийн ажил маань намайг ном, зохиол хэвлэх хэрэгт ойртуулан өгсөн юм. Ном хэвлэх машин гарч, анх монгол, төвдөөр хэвлэн эхэлж байв. Би хэвлэх машин дээр ажиллах болж, “Лайшийн хувилгааны зохиол” гэдгийг хэвлэн гаргасан. Тэр зохиолыг муутуу цаасан дээр хэвлэсэн шиг санагдаж байна. Автономитын үедингэж ном хэвлэж эхэлсэн тэр үеэс манай хэвлэх үйлдвэрийн эх үүсвэр гарсан. Дараа нь орос консулын газраас ном хэвлэх машин нэмж авсан. Ер нь тэгээд хэвлэх үйлдвэр өргөжиж эхэлсэн”⁴²

⁴⁰ Ринчен Б. *Монгол бичгийн хэлний зүй*, УБ, 1964, 59.

⁴¹ Дашням А. *Монгол оронд хэвлэл үүсч хөгжсөн т үүхээс*. УБ, 1962, 15-16.

⁴² Наваан Д. *Өвгөн Дэндэвийн дурдатгал*, УБ, 1961, 7-8.

гэжээ. Энэ үед Шанзавын буюу Их шавийн яамны дэргэд гар хэвлэлийн жижиг машин 1, чулуун хорын бар 1, бас бус зүйл байснаар тусгай жижиг хэвлэлийн газар байгуулсан бөгөөд энд 4 хүн ажиллаж, тус яамнаас харъяатолон отогт зарлан тушаах албан хэрэг, Богдын зарлиг, сургаал гэх мэтийн зэрэг зүйл хэвлэдэг байжээ⁴³. Энд анхаарах нэг зүйл бол бидний дээр дурдсан Гадаад яаманд чулуун хорын бар байсан нь нотлогдож байгаа явдал юм. Их шавийн хэвлэл тэрхүү чулуун барыг Гадаад яамнаас өөртөө авч, дээр нь Орос консулын буюу Орос-Монгол хэвлэлийн хорооноос гар хэвлэлийн жижиг машин авч, үйлдвэр байгуулжээ.

4. Автономитийн үеийн хэвлэл

Дээр дурдсан Ээндэн, Гомбожав, Гомбодоо, Гарамсоном, Чойдоо нарын дурдсанаас үзвэл, удалгүй Их шавийн хэвлэл автономитын Гадаад явдлын яамны дэргэдэх хэвлэлтэй нийлж, “Зарилгаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” 34 дэвтэр, Монгол, Хятад, Орос гурван улсын гэрээ бичиг зэрэг ном хэвлэсэн бөгөөд Гадаад яамны тэр хэвлэлд манай гайхамшигт жанжин Сүхбаатар тэргүүтэй хэд хэдэн хүн ажиллаж байжээ⁴⁴.

Эндээс үзэхэд, 1917 оны сүүлчээр Богд хааны зарилигаар Монгол Улсын шаштир хуулийг хэвлэн гаргах болсонтой холбоотойгоор хэвлэлийн үйлвэрийн хүчин чадлыг төвлөрүүлэн нэмэгдүүлэх шаардлага гарсан ажээ. Ийнхүү Гадаад яамны ба Их шавийн яамны хэвлэх үйлвэрүүд нэгдэж “Монгол хэвлэлийн хороо” нэрийн доор ажиллах болсон байна.

Тэр үед техник, хэвлэлийн цаас, монгол үсгийг Хятадын Харбин хотоос авах боломж бас байсан юм. Үүнд Харбинд ажиллаж байсан хэвлэлийн мэргэжлийн ажилчид Монголд ирж ажиллах болсон нь мөн нөлөөлсөн ажээ. Шанзавын хэвлэл цаас, зарим машин техникээ Хятадаас авч байсан бол, Гадаад яамны “Монгол хэвлэлийн хороо” хэвлэх үйлдвэр маань хойт хөршөөсөө (гол төлөв Санкт-Петербург, Казань, Эрхүү хотоос) үсэг тэмдэгтээ авдаг байсан нь монголчууд эдгээр газарт олноор оршин сууж амьдарч байсантай холбоотой⁴⁵.

Монгол улсад дээрх мэт хэвлэх үйлдвэрүүд байгуулагдан ажиллаж байсныг БНМАУ-ын түүх нэгэн боть зохиолд,

“Орос-Монголын анхдугаар хэвлэлийн газар ХХ зууны эхээр байгуулагджээ. Тэр нь 20-иод орос, монгол ажилчинтай, хэвлэлийн хэдэн гар машинтай өчүүхэн газар байлаа. Автономитын үед Гадаад явдлын яамны харъяанд Монголын хоёрдугаар хэвлэлийн газрыг байгуулжээ. Тэр нь голдуу албан бичиг болон мөн сурах, унших бичгийг хэвлэдэг байжээ. Тэр үед бас Их шавийн яамны дэргэд чулуун барт хэвлэлийн

⁴³ Дашням А, Мягмаржав Б. *БНМАУ-ын хэвлэлийн үүсэл хөгжлийн түүхэн төлөв*, УБ, 1956, 7.

⁴⁴ Дашням А. *Монгол оронд хэвлэл үүсч хөгжсөн түүхээс*, УБ, 1962, 15-16.

⁴⁵ *Зууны босгыг барласан түүх*, УБ, 2012, 6.

газар байгуулж, их төлөв тус яамны албан бичгүүд, Богд хааны лүндэн сургаал, зарлигийг хэвлэдэг байв”⁴⁶

хэмээн дүгнэжээ. Энэ нь Монгол Улс тусгаар тогтнолоо авсны дараа байгуулагдсан Гадаад явдлын яамны хэвлэлийг Автономитын үед байгуулагдсан гэж ташаарсан ноцтой алдаа болно.

Энд анхаарах ёстой асуудал бол 1915 оны 5 дугаар сарын 25-нд гарын үсэг зурсан гурван этгээдийн гэрээгээр Монгол улсыг “автономит Монгол” хэмээн нэрлэх болсонтой холбоотойгоор Оросын тал Консулын хэвлэлийн “Орос-монгол үсгийн хэвлэлийн хороо” гэдэг нэрнээс монгол гэдэг үгийг хасч, “Орос хэвлэлийн хороо” нэртэй болгож, Орос Улсаас ажиллаж байсан санхүүгийн зөвлөх Козины мэдэлд шилжүүлсэн байгаа юм. Монгол гэдэг үгийг хассан нь Гурван улсын гэрээгээр Монголын эрхийг хязгаарлаж, Хятадын автономит болгосонтой холбоотой байжээ. Үүнийг зарим судлаачид шинээр хэвлэх үйлдвэр байгуулагдсан мэтээр бичсэн тохиолдол бий. Тухайлбал, эрдэмтэн Ц.Пунцагноров “Автономит Монголын үед 1915 оноос орос зөвлөхийн газар ...хэвлэлийн хороо... байгуулах ажилдоржээ”⁴⁷ гэж ташаарчээ.

Орос хэвлэлийн хороо ба Монгол хэвлэлийн хороо хоёр хоорондоо маш ойр холбоотой ажиллаж, хэн алиныхаа хүчин чадал, нөхцөл бололцоог харгалзан харилцан туслалцаж хамтран ажиллаж байсныг Б.Ринчен доктор “Гадаад яамны хэвлэл, орос үсгийн хэвлэлийн хорооноос монгол ном баахан хэвлэн гаргадаг байжээ”⁴⁸ хэмээн тэмдэглэсэн байдаг. Түүгээр ч брахгүй 1918 онд Монголын хууль зүйн бичиг, түүх шаштир хэвлэх болоход бүх хэвлэх үйлдвэр хүчин чадлаа нэмэгдүүлж нэгдэж ажилласан байгаа юм.

Монголын автономитын засгийн газрын шийдвэрээр “Монгол улсын хууль зүйн бичиг, түүх шастирыг зохиох газар байгуулагдаж”⁴⁹, тэр үед Монголын засгийн газрын санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байсан С.Я.Козины мэдэлд байсан Консулын хэвлэлийн хороо, Гадаад яамны хэвлэх болон Их Шавийн хэвлэх үйлдвэртэй нэгдэж хэвлэлийн хүчин чадлыг өргөжүүлсэн байна. Энэ талаар тэр үед нэгдсэн хэвлэлийн үйлдвэрийн эрхлэгчээр ажиллаж байсан Ч.Хайдав,

“8 оны (1918) үед Шанзавын яам, Гоожин (Козин С.Я) ноёны хэвлэлийн машинуудыг Гадаад яамны хэвлэлд нийлүүлэн нэгтгэж, Монгол Улсын хууль, түүх шаштир хэвлэх газар болгоход Хайдав би тэр хэвлэлийн эрхлэгч болсон. Манай хэвлэлд Их шавиас Эндэн зайсан, Норовсүрэн, Чой их Доржпалам, бага Доржпалам нар, Цэцэн хаан аймгаас Далай

⁴⁶ БНМАУ-ын түүх, УБ, 1955, 272.

⁴⁷ Пунцагноров Ц. *Монголын Автономит үеийн түүх*, УБ, 1955, 91.

⁴⁸ Ринчен Б. *Монгол бичгийн хэлний зүй*. УБ., 1964, 59.

⁴⁹ Дүгэрсүрэн Л. *Улаанбаатар хотын түүхээс*, УБ, 1956, 66.

вангийн Дамдингийн Жамсран, Захын жүн ван (То-ван)-ийн өндөр Дамдин, Ачитын хушууны хүүхэн хэмээх Дамдин, Естын хушууны Сүхбаатар нар, Түшээт хаан аймгаас алтан шүдэт Намсрай, Япон Данзан зэрэг хүмүүс байсан. Манай үсэг хянагч нар Манжич Бат-Очир, Жамьян хоёр байдагсан”⁵⁰

гэж дурсан ярьжээ. Энд нэр дурдагдах хүмүүсээс Д.Сүхбаатар хэрхэн хэвлэлд ажиллах болсон талаар түүний намтарт, “автономит засгийн газар нь 1918 оноос монголын хууль, шастир хэвлэн гаргах болж бичиг үсгийн боловсрол чадвартай хүмүүсийг хэвлэлийн газар татан ажиллуулах болжээ. Тэгэхэд Д.Сүхбаатарыг Цэргийн яамнаас тэнд үсэг өрөгчийн ажил хийлгэхээр түр шилжүүлэн авчээ”⁵¹ гэсэн байна. Үүнтэй холбогдуулан ардын хувьсгалын партизан Д.Эндэн,

“Би Автономит төрийн 8 (1918) оны хавар хэвлэх үйлдвэрт орж ажиллахад Сүхбаатар тэнд ажиллаж байсан. Сүхбаатар түүх шастир өрөх ажилд гарамгай оролцсон гэж шагнуулсан айлтгалын бичиг нь одоо архивт бий. Намсрай, Сүх бид нар үсэг өрдөг, монгол үсгийг Намсрай бид хоёр өрдөг байсан. Ганцхан машинтай, механик нь Кучеренко байсан. Бас Тарханова гэдэг хоёр орос хүүхэн байсансан. Би 15 янчаан авдаг байсан нь тэр үедээ их мөнгө байж билээ. Сүхбаатартай хамт ажиллаж байснаас Чойдоо, Намсрай, Чогийн Хайдав нар байна. Сүхбаатар бол аятайхан зантай наргиач хүн байсан. Бид Гоймонбаатар гэдэг байсан...”⁵²

гэж дурсчээ. Үнэхээр 1919 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “...Машины үсэг хэвлэх албанд зүтгэсэн... Цэцэн хан аймгийн ...ёст бээс Доржжавын хушууны гутгаар зэрэг тогосын отго Сүхбаатарыг нэгэн зэрэг дэвшүүлэх хишиг хүртээх”⁵³ гэж Сүхбаатарт дэд зэрэг шагнасан баримт архивт байна. Ч.Хайдав цааш нь дурдахдаа,

“1919 онд Гамингийн мэдэлд Монгол хэвлэлийг шилжүүлэн авахад Хайдав би хэвлэлээс халагдаж, алтан шүдэт Намсрай хэвлэлийн эрхлэгч болсон. Гаминд хэвлэл шилжихэд өндөр Дамдин, Жамсран, их Доржпалам, хүүхэн Дамдин, Сүхбаатар нар тэндүлдэж ажилласан юмсан ... Сүхбаатар 1918 оны 10 дугаар сард хэвлэлд ажил хийж эхэлсэн, тэгэхдээ цэргээс халагдсан цаг. ... Тэгээд Сүхбаатар хэвлэлд сайн ажилласан учир 1919 онд шагнагдсан. Сүхбаатар 1920 оны хавар 3 сард хойшоо Орост анх удаа нууцган явахдаа хэвлэлийн даамал алтан шүдэт Намсрайгаас хувийн хэргээр оролдох 15 хоногийн чөлөө гуйж аваад явсан юм шүү. Мөн 1920 оны намар 10 сард Орост дахин нууцаар явах болоод хэвлэлээс гарах шалтаг зааж чөлөө гуйхад алтан шүдэт Намсрай “Сүхбаатар чи орондоо

⁵⁰ Содномдаржаа. Т Монгол ард улсын ном хэвлэлийн хураангуй түүх, УБ, 1965, 88.

⁵¹ Д.Сүхбаатарын намтар, УБ, 1967, 28.

⁵² Номын ууган орд, УБ, 1972, 37.

⁵³ МУТА, 1-24-55.

Хайдавыг олж оруулаад яв” гэсэн юм гэнэ лээ. Би тэр үед Гамингийн байгуулсан “дөрвөн аймгийн төлөөлөгчийн газар” гэдэгт бичээч болоод байсан. Тэгээд би Сүхбаатарын оронд ороод, Сүхбаатар хэвлэлээс халагдсан юм”⁵⁴

гэжээ. Эндяригдаж байгаа үйл явдал бол 1919 оны намар нийслэл Өргөөнд 12000 цэрэгтэй орж ирж, Монголын автономит засгийн газрыг сүрдүүлж, цэргийн хүчээр далайлган, хүссэн зүйлээ засгийн газарт хүчээр тулгахын хамт, тус улсын дотор цэргүүдээр тонуул дээрэм хийлгэж, дураар тавьснаас болж, улс орон цэргийн дарамтан дор гаслан гиншин зовж байгаа зэрэг генерал Сүй-ши-жэний бүхий хууль бус үйл ажиллагааны⁵⁵ үед хэвлэл түүний мэдэлдорсныг хэлж буй хэрэг юм.

Д.Сүхбаатар ийнхүү хэвлэлийн хороонд ажиллаж байхдаа тэнд үсэг өрөгч, механикчаар ажиллаж байсан М.И.Кучеренко, Монгол мэдээний газрын ажилтан И.С.Маслаков, Хүрээн дэх Оросын захиргааны нарийн бичгийн дарга В.Я.Гембержевский нарын дэвшилт үзэлтнүүдтэй танилцаж С.Данзангийн зохион байгуулсан хувьсгалт бүлгэмд орсон билээ. 1920 оны сүүлчээр Нийслэл Хүрээнд барон Унгерн байрлаж байхад, Өргөөнд большевизмын үрийг таригч Кучеренко, Гембержевский нар арьсаа хамгаалахын тулд орох байх газраа олж ядан байсан гэлцдэг юм. Тэгээд бароны дивизид сайн дурын цэрэг болж шалавхан бүртгүүлсэн боловч амиа аварч чадсангүй. Урьд өмнийн үйл ажиллагаа нь төдхөн илэрч алуурчдын гарт амиа алдсаныг тэр үеийн үймээнийг нүдээр үзсэн сэтгүүлч Д.П.Першин 1933 онд дурссан буй⁵⁶.

Дүгнэлт

1921 оноос өмнө нийслэл Хүрээнд ажиллаж байсан дээрхи гурван хэвлэлийн газар нь Монгол улсын орчин цагийн хэвлэх үйлдвэр үүсч хөгжих үндсэн суурь болсон төдийгүй соёлын болон улс төрийн асар их үүрэг гүйцэтгэсэн түүхтэй юм. Нийслэл Хүрээнд эдгээр хэвлэх үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулахад оросуудын нөлөө, тусламж, оролцоо шийдвэрлэх ач холбогдолтой байжээ. Хэвлэх үйлдвэрүүд хэдийгээр бага хүчин чадалтай хэвлэх машинаар тоноглогдсон байсан боловч тэнд тогтмол хэвлэл, ном сурах бичиг, албаны материал хэвлэж зорилгоо биелүүлж байв. Европт хэрэглэж байсан хэвлэлийн төхөөрөмж ийнхүү Монгол улсад нэвтэрснээр модон барын гар аргыг хөнгөвчилж механикжсан дэвшилттэй аргадшилжих эхлэл тавигджээ. Орчин цагийн хэвлэх үйлдвэрүүд ажиллаж эхэлсэн нь Монголын ном хэвлэлийн ажлын хөгжлийн түүхэн дэх онцгой үйл явдал байжээ.

⁵⁴ Содномдаржаа, Т. *Монгол ард улсын ном хэвлэлийн хураангуй түүх*, УБ, 1965, 88-89.

⁵⁵ Першин Д.П. *Барон Унгерн, Өргөө Алтанбулаг*. УБ, 2003, 33.

⁵⁶ Мөн дээрх, 130.

Abstract: In 1912, during the Bogd Khan Emperor in Mongolia, the printing industry established to publish books and newspapers by using the modern mechanical technology in Niislel Khuree. The First publishing industry was opened by the Russians in 7 November, 1912 and published books and newspapers in Mongolian language. At the end of 1912, Mongolians established its own publishing industry at the Foreign Ministry to publish main political documents. In 1916, the Shanzav Ministry Publishing industry has been started to publish Bogd Khan's messages, announcements and calendar etc. The above mentioned three printing and publishing factories which established before the National Democratic Revolution in Niislel Khuree has been the fundamental for the development of Mongolian Modern Publishing industry and also played major role in the cultural and political history of Mongolia. The Russians has been supported and influenced to establish and run these factories. The factories were equipped with the low capacity printing machine however; they had been printing newspapers, books and documents regularly. Therefore, the European technology entered to the Mongolia has been the start of the new mechanical technology which improved the method of Wooden printing block used earlier. The start of the modern printing and publishing industry plays special role for the development of the Mongolian literature.